



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/99

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт, сувилалын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах, дэмжих зорилгоор гэрээний дагуу 24 039 900 төгрөгийг хавсралтаар баталж, батлагдсан хуваарийн дагуу зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 24 039 900 төгрөг /хорин дөрвөн сая гучин есөн мянга есөн зуу/-ийг Засаг дарга данснаас хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
03 дугаар сарын 03-ны өдрийн  
А/99 дүгээр захирамжийн хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН “СУРГАЛТ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ”,  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ОНД  
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Нэр	Албан тушаал	Хүний тоо	Сарын цалин	Жилийн нийт цалин	НОАТ	НДШ	Ажиллагсадтай холбоотой зардлын нийт дүн
1	Б.Сүхбаатар	тэргүүн	1	420,000	5,040,000	504,000	730,800	3,805,200
Нийт								5,040,000
<b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН ХОЛБООНЫ ХОВД САЛБАРЫН ДЭРГЭДЭХ ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ ТӨСӨВ</b>								
1	Албан тушаал	Тоо	Сарын цалин	Ажиллах сар	Жилийн цалингийн дүн	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	Зардлын нийт дүн	
1	Менежер	1	495,000	12	5,940,000	801,900	6,741,900	
2	Багш	1	450,000	12	5,400,000	729,000	6,129,000	
3	Хөдөлгөөн засалч сувилагч	1	450,000	12	5,400,000	729,000	6,129,000	
	Нийт		1,395,000			2,259,900	18,999,900	
ДҮН								24,039,900

-oOo-